

“Авлигатай тэмцэж шударга ёсыг тогтоон бэхжүүлэх нь: Асуудал ба шийдэл”
сэдэвт оюутны эрдэм шинжилгээний бага хурал

Сэдэв:

「Авлигатай тэмцэхэд хараат бус, чөлөөт
хэвлэл мэдээллийн оролцоо, гүйцэтгэх үүрэг
буюу Чөлөөт хэвлэл мэдээллээс олон нийтийн
эвлэл холбоо руу」

Монгол Улсын Их Сургууль
Хууль Зүйн Сургууль
Японы Эрх Зүйн 4-р анги
М.Цэнд-Очир

Улаанбаатар хот

2011 он

Илтгэлийн дотоод системчлэл:

I. Удиртгал хэсэг

- 1.1. Сэдвийг сонгосон үндэслэл
- 1.2. Сэдвийн судлагдсан байдал
- 1.3. Эрдэм шинжилгээний шинэлэг тал
- 1.4. Судалгааны зорилго, зорилт
- 1.5. Судалгааны объект, судлах зүйл
- 1.6. Судалгааны арга зүй
- 1.7. Судалгаагаар дэвшүүлж хамгаалалтад оруулж буй үндсэн асуудлууд
- 1.8. Судалгааны онол практикийн ач холбогдол

II. Үндсэн хэсэг

- 2.1. Тодорхойлох хэсэг буюу асуудлыг томъёолох нь
 - 2.1.1. Авлига гэж юу вэ?
 - 2.1.1.1. Ашиг сонирхолын зөрчилдөөн
 - 2.1.1.2. Ашиг сонирхолын зөрчилдөөнөөс авлига руу
 - 2.1.1.3. Авлига гэж юу вэ?
 - 2.1.2. Монголын нийгэм дэх авлигын өнөөгийн байдал
 - 2.1.2.1. Авлигын талаарх судалгаа
 - 2.1.2.2. Монгол дах авлигын эсрэг хууль, тогтоомж
 - 2.1.2.3. Авлигтай тэмцэж буй арга зам, түүний үр дүн
- 2.2. Үндэслэх хэсэг буюу асуудлыг дэвшүүлэх нь
 - 2.2.1. Хараат бус, чөлөөт хэвлэл мэдээлэл гэж юу вэ?
 - 2.2.2. Авлигатай тэмцэхэд хараат бус, чөлөөт хэвлэл мэдээллийн оролцоо, түүний баталгаа
 - 2.2.3. Авлигатай тэмцэхэд хараат бус, чөлөөт хэвлэл мэдээллийн үүрэг
 - 2.2.4. Авлигын эсрэг тэмцэхэд хэвлэл мэдээллийн оролцоонд тулгарч буй асуудал
- 2.3. Тогтоох хэсэг буюу асуудалд гарц хайх нь
 - 2.3.1. Иргэний нийгэм дэх олон нийтийн эвлэл холбоо
 - 2.3.2. Авлигатай тэмцэхэд олон нийтийн эвлэл холбооны гүйцэтгэх үүрэг
 - 2.3.3. Хараат бус, чөлөөт хэвлэл мэдээллээс олон нийтийн эвлэл, холбоо руу

III. Дүгнэлт хэсэг

- 3.1. Дүгнэлт
- 3.2. Санал, зөвлөмж

IV. Ашигласан материал

"Чөлөөт хэвлэл бол чөлөөт ард иргэд мөн"

(“Чөлөөт хэвлэлийн харти”-аас)

I. Удиртгал хэсэг

1.1. Сэдвийг сонгосон үндэслэл

"I detest what you say, I will defend to the death your right to say it"/Voltaire/ гэж 18-р зууны үеийн зохиолч, философич Волтейр хэлсэн байдаг. Утгачилвал, “Би чиний хэлж буйг маш ихээр үзэн ядаж зэвүүцнэ. Гэхдээ би чиний үүнийг хэлэх эрхийг чинь мөхөж, үгүй болохоос хамгаалах болно” гэсэн санаа гарч ирнэ. Саяхан “БОАЖЯ-ын сайд Л.Гансүхийг 100 сая төгрөгийн хаус хэрхэн авч суусан талаарх нийтлэл бичсэн А.Баатархуяг, энэ талаар олон нийтэд ярьсан Г.Уянга нар буюу гэр бүлийн хоёр сэтгүүлчийг хүн гүтгэсэн хэргээр Л.Гансүх сайд гомдол гаргажээ”¹ гэсэн мэдээ гарч ирж, удалгүй, А.Баатархуяг, Г.Уянга нар нь Л.Гансүхийг гүтгэсэн гэсэн үндэслэлээр, шүүхээс шийтгэл оногдуулсан. Авлига авсан гэх мэдээлэл гүтгэлэг хийсэн гэсэн шүүхийн шийдвэр болж хувирсан. Уг нь тэд сэтгүүлч. Нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлсэн, сэжиг байгаа болохоор сэтгүүлчийн хардах эрхээ хэрэгжүүлсэн гэж иргэд үзэх болов. Өнөөдөр авлигын эсрэг тэмцэл дэх сэтгүүлч, чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийн үүрэг оролцоо ийнхүү хүчгүйдэлд орж, мухардаж байна гэдэг нь энэ кейсээс ойлгогдоно. Иймийн учир, Авлигатай тэмцэх явдалд хараат бус, чөлөөт хэвлэл мэдээллийн оролцоо, үүрэг, ямар байх вэ, тулгарч буй асуудал нь юунд байна, тэрхүү асуудлыг хэрхэн, шийдэж, үүрэг, оролцоог нь яаж хүчирхэгжүүлэх вэ гэдэг үүднээс “Авлигатай тэмцэхэд хараат бус, чөлөөт хэвлэл мэдээллийн оролцоо, гүйцэтгэх үүрэг буюу Чөлөөт хэвлэл мэдээллээс олон нийтийн эвлэл холбоо руу” гэсэн сэдвийг сонгосон болно.

1.2. Сэдвийн судлагдсан байдал

Уг сэдвийн хүрээнд цөөнгүй судалгаа, шинжилгээний бүтээлүүд байх бөгөөд тухайлбал, Филлипин улсын ерөнхийлөгч Эстрадагийн авлигын хэргийг илчлэн түүнийг огцруулахад хүргэсэн филлипины эрэн сурвалжлах төвийн үйл ажиллагааны талаар туурвисан “Ерөнхийлөгчийг огцруулсан сэтгүүлчийн нөр их хөдөлмөр”, судлаач Г.Цогтбаатарын бичсэн авлигын эсрэг тэмцэлд хэвлэл мэдээллийн үүрэг ямар байх талаар “авлигатай тэмцэхэд чөлөөт хэвлэлийн үүрэг”, МҮХАҮТ-с гаргасан “авилгалын эсрэг тэмцэлд хэвлэл мэдээллийн байгууллагуудын оролцоог эрчимжүүлэх нь” хурлын эмхэтгэл, авилгатай тэмцэх засгийн газрын хөтөлбөрийн зөвлөх, хуульч Фридрих Эриксоны “мэдээллийн эрх чөлөө, авилга” зэрэг бүтээлүүд гарчээ. Эдгээр бүтээлүүд нь голчлон авлигад хэвлэл мэдээллийн үүрэг ямар байх вэ гэдэг тал дээр чухалчилж судалсан байгаа боловч, бодитоор ямар бэрхшээл тулгарч байгаа, тэрхүү бэрхшээлийг даван туулах арга зам юу вэ гэдэг талаас нь судлагдсан байдал дутмаг байна гэж үзсэн болно.

1.3. Эрдэм шинжилгээний шинэлэг тал

¹ <http://yahuu.mn/> /мэдээллийн вебсайт/

Дээрх хэсэгт тус сэдэв ямар өнцгөөс судлагдсан талаар дурдсан. Үүн дээр үндэслээд, авлигатай тэмцэхэд хэвлэл мэдээллийн оролцоог эрчимжүүлэх, хүчирхэгжүүлэх явдалд олон нийтийн эвлэл холбоо, байгууллага чухал үүрэгтэй гэх өнцгөөс судлагдсан байдал нь уг судалгааны шинэлэг тал гэж үзсэн болно.

1.4. Судалгааны зорилго зорилт

Авлигатай тэмцэх явдалд хараат бус, чөлөөт хэвлэл мэдээлэл болон олон нийтийн эвлэл холбоо, байгууллага хоёрын уялдаа холбоо чухал бөгөөд авлигын эсрэг хамгийн хүчтэй тэмцэх арга механизм мөн гэдгийг батлах зорилгын хүрээнд,

- Авлига гэж юу болох, өнөөгийн Монголын нийгэм дэх авлигын байдлыг тодруулах
- Авлигатай тэмцэхэд хараат бус, чөлөөт хэвлэл мэдээллийн үүрэг, оролцоо юу болох, тэдгээрт тулгамдах асуудлыг гаргаж ирэх
- Авлигатай тэмцэхэд хараат бус, чөлөөт хэвлэл мэдээллийн үүрэг, оролцоонд тулгамдах асуудлыг яаж шийдвэрлэж болох, энд олон нийтийн байгууллага, эвлэл холбооны үүрэг, оролцоо ямар байх вэ гэдгийг дэвшүүлэх

гэсэн зорилтуудыг дэвшүүлсэн болно.

1.5. Судалгааны объект, судлах зүйл

Судалгааны судлах зүйл, объект нь авлига, хэвлэл мэдээллийн эрх чөлөө, олон нийтийн байгууллага, эвлэл холбоо гэсэн ухагдахуунуудын хүрээнд байна.

1.6. Судалгааны арга зүй

Судалгаанд шинжлэх ухааны судалгааны ерөнхий аргууд болох анализ-синтез, харьцуулалтын арга, системт хандлагын арга зэргийг ашигласан болно.

1.7. Судалгаагаар дэвшүүлж хамгаалалтад оруулж буй үндсэн асуудлууд

Авлигын эсрэг тэмцэж, авлигыг таслан зогсооход хэвлэл мэдээллийн чөлөөт, хараат бус сэтгүүл зүй хийгээд нийгмийн хамгийн хүчирхэг эрх мэдлийг барьж байдаг иргэдээс бүрдсэн олон нийтийн эвлэл холбоо, байгууллагын харилцан уялдаа холбоо бүхий тогтолцоо туйлын үр дүнтэй гэсэн асуудал болно.

1.8. Судалгааны онол практикийн ач холбогдол

Авлигатай тэмцэх явдалд хараат бус, чөлөөт хэвлэл мэдээлэл болон олон нийтийн эвлэл холбоо, байгууллага хоёрын уялдаа холбоо чухал бөгөөд авлигын эсрэг хамгийн хүчтэй тэмцэх арга механизм мөн гэдэг батлагдаж, авлигатай тэмцэхэд хэвлэл, мэдээллийн оролцоонд тулгарч буй мухардалыг олон нийтийн оролцоогоор шийдвэрлэх явдал нь зөв гарц мөн гэдэг нь нотлогдож чадвал, энэ авлигын эсрэг тэмцэлд оруулж буй хувь нэмэр буюу практик ач холбогдол гэж ойлгоно.

II. Үндсэн хэсэг

2.1. Тодорхойлох хэсэг буюу асуудлыг томъёолох нь

2.1.1. Авлига гэж юу вэ?

2.1.1.1. Ашиг сонирхолын зөрчилдөөн

Авлига гэдэг асуудлыг сөхөж тавихаас өмнө, авлига үүсэн бий болох урьдчилсан нөхцөл болдог ашиг сонирхолын зөрчилдөөний талаар авч үзье. Эрдэмтэн Л.Батжав нар “хэн нэгэн хувь хүн өөрийн мэдлэг, мэргэжил, авъяас чадвар, арга залийн аль нэгээр, эсхүл аль алийг нь хослуулан албан тушаалаа ахиулах, авдаг цалингаа нэмэгдүүлэх, амьдрал ахуйгаа дээшлүүлэхэд чиглэсэн эдийн болон эдийн бус тааламжтай нөхцөл, боломжийг өөртөө бий болгож байгаа аливаа үйлдэл, ажил, үйлчилгээг ашиг сонирхолын зөрчил гэж ойлгоно”² гэж тодорхойлсон байна. Хүн бүрт л ашиг сонирхол гэж байдаг. Гагцхүү, тухайн хувь хүн өөрт буй ашиг сонирхолоо биелүүлж чадах уу, эс чадах уу гэдэг нь тухайн хүний авъяас чадвар, хөдөлмөр, сэтгэлгээтэй хамааралтай юм. Ашиг сонирхлын зөрчлийн талаар илүү нарийвчилж үзвэл, “төрийн албан тушаалтнаас үүргээ гүйцэтгэхэд албаны болон хувийн сонирхол зөрчилдөх буюу төрийн албан тушаалтны хувийн сонирхол нь албан үүргээ гүйцэтгэхэд нь харшаар нөлөөлөхийг”³ хэлнэ⁴ гэсэн тодорхойлолт гарч ирнэ.

2.1.1.2. Ашиг сонирхолын зөрчилдөөнөөс авлига руу

Хүн үүсэхэд зэрэгцэн бий болсон нэгэн зан чанар бол шунал, эдийн сонирхолд автах явдал байдаг. Өөрөөр хэлбэл, ямар ч хүн өөрийн амьдралд хэрэгцээтэй материаллаг зүйлийг байнга хүсэмжилж байдаг буюу албан тушаалаа ахиулах, амьдрал ахуйгаа дээшлүүлэхэд чиглэсэн эдийн болон эдийн бус тааламжтай нөхцөл, боломжийг өөртөө бий болгох гэсэн ашиг сонирхол явж байдаг. Гагцхүү энэ ашиг сонирхолыг байх ёстой хэмжээнд нь байлгах уу, эсвэл дээр дурдсанчлан шунал, зүй бус сэтгэхүйдээ хөтлөгдөн хэмжээнээс нь хэтрүүлэх гэдэг нь тухайн хүний ухамсар, хүмүүжил, мөн чанараас хамаарна⁵. Чухам эндээс л авлига гэсэн асуудал үүсэн бий болдог байна. Өөрөөр хэлбэл, “сонирхлын зөрчил гэсэн ойлголт нь нэг талаас ёс зүйн шаардлага болох хэдий ч нөгөө талаас авлигын сүүдэр, шалтгаан болж яригддаг. Энэ ойлголтыг зарим судлаачид авлига гэж үзсэн байхад зарим судлаачдын судалгааны бүтээл, эх сурвалжид хараахан авлига биш харин авлига бий болох эрсдэл гэж үздэг”⁶ гэж дүгнэснээс үзвэл, ашиг сонирхлын зөрчил нь авлига бий болох нөхцөл болдог гэдэг нь харагдаж байна.

² Л.Батжав, Б.Цэвээн, “Ашиг сонирхолын зөрчил”, УБ, 2009, 12-р тал

³ НДЭХ, “Төрийн албан дах сонирхлын зөрчлийн менежмент” гарын авлага, УБ, 2007

⁴ С.Оюунтуяа, “Сонирхлын зөрчлийн тухай ойлголт, Монгол улс дах сонирхлын зөрчлийн нөхцөл байдал, түгээмэл хэлбэрүүд” нийтлэл, АТГ, “Шударга ёс” сэтгүүл, 06-р дугаар, УБ, 2011, 32-р тал

⁵ Л.Батжав, Б.Цэвээн, “Ашиг сонирхолын зөрчил”, УБ, 2009, 9-р талд тус санааг илэрхийлжээ.

⁶ С.Оюунтуяа, “Сонирхлын зөрчлийн тухай ойлголт, Монгол улс дах сонирхлын зөрчлийн нөхцөл байдал, түгээмэл хэлбэрүүд” нийтлэл, АТГ, “Шударга ёс” сэтгүүл, 06-р дугаар, УБ, 2011, 35-р тал

2.1.1.3. Авлига гэж юу вэ?

Авлига гэж ямар учиртай ойлголт болох талаар хууль зүйн, үг зүйн, түүхэн, онцлог мэргэжлийн гээд олон талаас нь авч үзсэн маш их тодорхойлолт бий.

Үг зүйн үүднээсээ, авлига гэдэг нь “гадны нөлөөгөөр химийн болон электрохимийн урвалд орсны улмаас металл үндсэн шинж чанараа алдахыг нэрлэсэн утгатай **corruptio** гэсэн латин үгнээс гаралтай⁷ **corruption** хэмээх англи нэр үг нь шударга бус, хээл хахууль авдаг, ёс суртахуунгүй, зан чанар нь эвдэрсэн, ялзарч доройтсон байдлыг илэрхийлдэг⁸ утгатай”⁹ хэмээсэн байна. Түүнчлэн монгол хэлний утга зүйн талаасаа авлига гэдэг үг нь “эдэд шунах, ёсон бус аргаар юмыг олзолж авах, хээл хахууль”¹⁰ гэдэг утгатай байна. Мөн Японд авлига гэдэг ойлголт нь “улсын дээд эрх мэдэл баригчын төлөөлөл болж нийтийн эрх мэдлийг хэрэгжүүлж буй төр, улс төрийн зүтгэлтэн, захиргааны байгууллагын ажилтан нар нь тухайн эрх мэдлийн хэрэгжилт, шийдвэрийн зүй зохист, үнэн бодит байдлыг зөрчүүлж, өөрийн талд гаргуулахаар хүсч буй этгээдээс хууль болон нийтийн ёс суртахуунд харшилсан байдлаар хүлээж авах эд зүйл, үйлчилгээ юм”¹¹ гэж тайлбарлажээ.

Хууль зүйн утгаараа авлига гэдэг нь “ энэ хуулийн 4.1¹²-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг”¹³ хэлнэ гэсэн байна.Түүнчлэн, авлигын талаар Америкийн улс төр судлаач К.Фридрих “Нийгмийн ашиг сонирхолыг худалдсанаар хувийн ашиг сонирхолыг хангах зүй бус үзэгдэл” гэсэн бол судлаач Д.Бэйли “Коррупци гэдэг нь эрх мэдлийг хувийн сонирхолдоо ашиглахыг хэлнэ”¹⁴ гэх зэргээр нийгмийн сэтгэлгээний түвшинд тодорхойлсон байна. Мөн авлигыг “бусдын ашиг сонирхолыг худалдсанаар өөрийн хувь сонирголоо хангах зүй бус үйл ажиллагаа буюу бусдаас олгогдсон эрхийн хүрээнд тэдний ашиг сонирхолыг гүйцэлдүүлэх үүрэг бүхий этгээд хахууль өгөгчийн ашиг сонирхолын үүднээс бусдын эрх ашгыг хөсөрдүүлэн, амин хувийн зорилгоор ашиг орлого хөөцөлдөх дураар авирлал”¹⁵ гэж тайлбарласан тал ч байна.

⁷ С.М.Локшина, Краткий словарь иностранных, Москва, 1987, с.260

⁸ Joice M.Hawkings, The Oxford English Minidictionary, Clandon Press-Oxford, 1994, p. 110

⁹ Д.Зүмбэрэлхам, “Авлигын гэмт явдал-сургалтын гарын авлага”, УБ, 2007, 5-р тал

¹⁰ Я.Цэвэл, “Монгол хэлний товч тайлбар толь”, УБ, 1966, 16-р тал

¹¹ <http://ja.wikipedia.org/wiki/賄賂>

¹² Авилгын эсрэг хуулийн 4.1-т “төрийн улс төр, захиргаа, тусгай албан тушаалд байнга, эсхүл түр хугацаагаар томилогдсон буюу сонгогдсон албан хаагч; төрийн болон орон нутгийн өмчит, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон захиргааны албан тушаалтан; олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, Ерөнхий захирал; төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу түр буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах болон гүйцэтгэх ажилтан; энэ хуулийн 3.1.9-д заасан сонгуульд нэр дэвшигч” гэж тус тус заажээ.

¹³ Авлигын эсрэг хууль, УБ, 2006, 3.1.1 дэх заалт

¹⁴ Д.Бэхбаяр, “Жорж Сорос Монголд авилгад өртөх шахав” өгүүлэл, МННХ Соросын сан, Зориг сан, “Авилгал: Мөнхийн үзэгдэл биш”, УБ, 2002, 54-р тал

¹⁵ Л.Батжав, Б.Цэвээн, “Ашиг сонирхлын зөрчлөөс авлига руу”, УБ, 2009, 86-р тал

Авлига гэдэг нь маш өргөн хүрээтэй, олон асуудлыг хамарсан ойлголт билээ. Авлигын хор хөнөөл гэхэд л улс төр, нийгэм, эдийн засаг, хууль ёс, ардчилалд зэрэгт учруулж буй байдал, хэлбэр, төрлийн хувьд гэхэд хээл хахууль, шан харамж, бэлэг, тал тохой татах гэхчлэн олон янз. Энэ бүгд нь өөр өөрийн гэсэн учир шалтгаан, агуулга, зүй тогтолтой. Уг судалгааны ажил нь авилгал гэж юу вэ гэдэг асуудал дээр төвлөрөх бус, авлигын асуудалтай хэрхэн тэмцэх вэ, яаж шийдэх вэ гэдэг цэг дээр төвлөрч буй учир авлигын дээр дурдсан олон нарийн асуудлыг авч үзэлгүй орхисон болно.

2.1.2. Монголын нийгэм дэх авлигын өнөөгийн байдал

2.1.2.1. Авлигын талаарх судалгаа

Авлига нь дэлхий нийтийг хамарсан өргөн хүрээний асуудал болж, нэг талаараа бараг л энгийн үзэгдэл мэт болсон нь “Нэгэнтээ цаг хугацаа мөнгө байдаг болохоор компаниуд, хувь хүмүүс төвөг чирэгдлээс зайлсхийж, мөнгө атгуулахад бэлэн байдаг. Олон оронд хахуульдахгүйгээр гэрийн утас тавиулах, иргэний үнэмлэх, жолооны үнэмлэх түргэн авах боломж байдаггүй. Заримдаа нийтийн үйлчилгээг тэвчээртэй, хуулиа дагадаг иргэдэд бус, зөвхөн хахуульддаг өрсөлдөгч нарт үзүүлдэг”¹⁶ гэсэн үзлээс тодорхой харагдана. Тэгвэл өнөөгийн Монголын нийгэм дэх авлигын байдал ерөнхий түвшинд ямар байгаа талаар дараах судалгаануудаар авч үзье.

Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, монголын нийгэмд авлига түгээмэл үзэгдэл болсонтой санал нэгдэж байгаа эсэхээр./Хүснэгт №1/¹⁷


Үзүүлэлтүүд		Монголын нийгэмд авлига түгээмэл үзэгдэл болсон эсэх			
		Тийм	Үгүй	Нийт	Тоо
Хүйс	Эрэгтэй	95.9	4.1	100.0	244
	Эмэгтэй	97.2	2.8	100.0	249
Боловсролын түвшин	Бүрэн дунд	96.7	3.3	100.0	120
	Тусгай дунд	95.2	4.8	100.0	84
	Дээд	96.9	3.1	100.0	289
Ажил эрхлэлт	Төрийн байгууллага	96.1	3.9	100.0	231
	Хувийн хэвшил	97.9	2.1	100.0	97
	ТББ	100.0	-	100.0	28
	Хувиараа	96.3	3.7	100.0	81
	Ажилгүй	94.6	5.4	100.0	56
	БҮГД	96.6	3.4	100.0	493

Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, авлигыг дэмжин дэлгэрүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйлийг үнэлсэн байдлаар./Хүснэгт №2/¹⁸

¹⁶ С.Р.Аккерман, “Авлига, төр хоёр: Шалтгаан, үр, шинэтгэл”, УБ, 2007, 18-р тал /Орч. Ц.Цэрэн, Ж.Төртогтох/

¹⁷ МУИС, “Авилгалыг дэмжигч болон хориглогч хүчин зүйл” судалгааны тайлан, УБ, 2007

¹⁸ МУИС, “Авилгалыг дэмжигч болон хориглогч хүчин зүйл” судалгааны тайлан, УБ, 2007



Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, авлига, хээл хахуулийг багасгахад ач холбогдолтой хүчин зүйлсийг нэрлэнэ үү./Хүснэгт №3/¹⁹



Эдгээр судалгаанаас аваад үзэхэд, Монголд авлига нэгэнт газар авч, хүчтэй тархсан гэдгийг судалгаанд оролцогч иргэд дийлэнх олонх нь хүлээн зөвшөөрч, иргэдийн ойлгож буйгаар авлига гарч байгаа голлох шалтгаан нь энэ талаарх хууль эрх зүйн орчин хангалтгүй байна гэсэн хариулт дээр төвлөрсөн байна. Түүнчлэн, авлигатай тэмцэхэд, авлигын эсрэг хуулийг чангатгах хэрэгтэй,

¹⁹ МУИС, “Авилгалыг дэмжигч болон хориглогч хүчин зүйл” судалгааны тайлан, УБ, 2007

авлигатай тэмцэх тусгай байгууллага байгуулах хэрэгтэй, авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах хэрэгтэй гэх зэрэг үр дүн гарч ирсэн байна.

Мөн бусад судалгаа, тайлангуудаас авч үзвэл, “Авилгал нь төрийн бага дунд албан тушаалтан төдийгүй засгийн газар толгойлж буй ерөнхий сайдыг ч тойроогүй даамжирсан нэн хурц нийгмийн өвчин болсон байна”²⁰, тэрчлэн “Авилгал нь өнөөгийн Монголын нийгэмд өргөн тархсан, нэн түгээмэл үзэгдэл болох нь харагдаж байна. Судалгаанд оролцогчдын дийлэнхи олонхи нь /88.9 хувь/ Монголд авилгал дэлгэрсэн хэмээн хариулжээ. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогчид нь нас, хүйс, боловсрол, намын харъяалал, оршин суух газар зэрэг нийгэм-хүн ам зүйн үзүүлэлтээсээ үл хамаарч нийтээрээ Монголд авилгал нийгмийн бодит үзэгдэл болж хувирсан”²¹ зэрэг авлигын талаар хийгдсэн судалгааны үр дүнгүүд гарсан байна. Олон улсын түвшинд манай орны авлигын байдал ямар байгаа тал дээр, “Транспэренси Интернэшнл олон улсын төрийн бус байгууллагаас 2006 онд гаргасан судалгаанд Монгол Улс авлигын түвшинээрээ нийт 163 орноос 99-р байр эзэлж байна”²² гэсэн авлигын асуудал дотоод хийгээд гадаадад туйлын хурцадмал байдалд орсон гэдгийг илтгэсэн үр дүн харагдаж байна. Тэгвэл, энэхүү авлигад холбогдох асуудлыг шийдвэрлэх үүднээс, авлигын эсрэг ямар хууль, эрх зүйн орчин байдаг талаар дараагийн хэсэгт авч үзье.

2.1.2.2. Монгол дах авлигын эсрэг хууль, тогтоомж

Авлигатай тэмцэх талаар төрийн зүгээс хэрэгжүүлж буй нэг томоохон зүйл бол авлигын эсрэг хууль, тогтоомж, гэрээ, конвенцүүд юм. 1996 онд Авлигын эсрэг хуулийг батлаж, улмаар 2006 онд “авлигатай тэмцэх үйл ажиллагаа, авлигатай тэмцэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулана”²³ гэсэн зорилготой шинэ Авлигын эсрэг хуулийг батлаж мөрдүүлсэн байна. Мөн 2002 онд Авлигатай тэмцэр үндэсний хөтөлбөрийг батлан гаргаж, 2005 онд Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцид нэгдсэн орсон байна. Энэ мэтчилэн авлигын эсрэг тэмцэх явдалыг эрх зүйн хувьд баталгаажуулж, үндэстний, олон улсын хэмжээнд анхааран авч үзэж байгаа ч гэлээ авлига гэх асуудал нэг мөр шийдэгдэхгүй, асуудал байсаар байгаа нь судалгаа шинжилгээний үр дүн хийгээд нийгмийн практик амьдрал дунд ажиглагдсаар байгаа билээ. Энэ тал дээр, хууль эрх зүйн орчноос гадна, авлигын шалтгаан юу болох, улмаар тэдгээрийг шийдвэрлэхийн тулд ямар арга зам авч, мөн түүн дээр ямар асуудал тулгарч байгаа талаар дэлгэрүүлэн дараагийн хэсэгт авч үзье.

2.1.2.3. Авлигатай тэмцэж буй арга зам, түүний үр дүн

²⁰ “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-н хэрэгжилт, авлигатай тэмцэх талаарх олон нийтийн санаа бодол, УБ, 2004, 70-р тал

²¹ “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-н хэрэгжилт, авлигатай тэмцэх талаарх олон нийтийн санаа бодол, УБ, 2004, 73-р тал

²² Г.Цогтбаатар, “Авлигатай тэмцэхэд чөлөөт хэвлэлийн үүрэг” нийтлэл, УБ, 2008, 2-р тал

²³ Авлигын эсрэг хууль, УБ, 2006, 1-р зүйл

АНУ-н Олон Улсын Хөгжлийн Агентлаг болон Азийн сантай хамтран явуулсан Монгол дах авлигын байдалд хийсэн үнэлгээний үр дүнгээс үзвэл, авлига гарч буй шалтгаануудыг дараах байдлаар дүгнэжээ.

1. Ашиг сонирхолын зөрчилдөөн буюу “Хувийн ба төрийн ажлаа ялгаж салгадаггүйгээс төрийн албан хаагч төрийн ажлыг явуулахдаа бодитой бөгөөд хараат бусаар ажиллах зарчмыг зөрчдөг гэдгийг бараг мэддэггүй тул хувийн сонирхол ба албаны хариуцлагаа хутгадаг ажээ. Мөн төрийн албан хаагчид албан тушаалаа болон өөрт байгаа мэдлэг, мэдээллээ хувийн эрх ашигт зүй бусаар ашигладаг”²⁴ гэсэн дүгнэлт хийсэн байна. Тэгээд цааш нь доорх учир шалтгаан, хүчин зүйлийн улмаас авлига гарч буй талаар тус тусын дүгнэлт, нотолгоог хийжээ
2. Ил тод байдал болон мэдээлэл олж авах боломж хомс байдал
3. Төрийн захиргааны улс төржилт
4. Хянах ба хэрэгжүүлэх байгууллагууд
5. Сонгуулийн ба улс төрийн үйл явц
6. Улс төрийн хүсэл зориг
7. Олон нийтийн хязгаарлагдмал оролцоо
8. Нийгмийн ба соёлын хүчин зүйлс²⁵

Дээрх учир шалтгаан бүхий асуудалд хандаж, эдгээрийг шийдвэрлэх арга зам гэх үүднээс, дараах авлигатай тэмцэх алхамуудыг дэвшүүлсэн байна.

1. Олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх
2. Авлигатай тэмцэх төлөвлөгөө ба авлигатай тэмцэх үндэсний зөвлөл байгуулж ажиллах
3. Авлигатай тэмцэх хууль ба авлигатай тэмцэх байгууллага байгуулж ажиллах
4. Иргэний нийгмийн оролцоог сайжруулах²⁶ арга зам байж болох бөгөөд эдгээрийг хэрэгжүүлэх талаас нь дэвшүүлсэн байна. Эдгээр асуудлаас авлигын эсрэг хууль батлагдаж, авлигатай тэмцэх бие даасан байгууллага байгуулагдсан зэрэг алхамууд өнөөдөр нэгэнтээ тавигдаад байгаа ч авлигын асуудал цэгцтэйгээр шийдэгдэж чадахгүй байна. Энэ талаар ч судалгаа, шинжилгээ харуулж буй.

Эдгээрийг аваад үзэхэд, дээрх авлигын эсрэг тэмцэх аргуудын үр дүн төдийлөн сайн харагдахгүй байгаа бөгөөд эдгээр авлигын эсрэг тэмцэх аргууд дунд чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийн оролцоо гэдгийг анхаарч авч үзээгүй байна. Уг чанартаа, авлигын эсрэг тэмцэлд хамгийн том үүрэг гүйцэтгэх чадамжаараа анхаарал татаж буй хийгээд уг судалгааны төвлөрч буй цэг болох хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллагын оролцоо, үүргийн талаар авч үзэх

²⁴ АНУ-н ОУХА, Азийн сан, “Монгол улс дах авлигын байдалд хийсэн үнэлгээ” эцсийн тайлан, УБ, 2005, 18-р тал

²⁵ АНУ-н ОУХА, Азийн сан, “Монгол улс дах авлигын байдалд хийсэн үнэлгээ” эцсийн тайлан, УБ, 2005, 20-36-р тал

²⁶ АНУ-н ОУХА, Азийн сан, “Монгол улс дах авлигын байдалд хийсэн үнэлгээ” эцсийн тайлан, УБ, 2005, 54-64-р тал

нь тун чухал юм. Тэгвэл эндээс, хараат бус, чөлөөт хэвлэл мэдээлэл гэдэг авлигатай тэмцэхэд хичнээн чухал үүрэг, оролцоотой байдаг, тэрхүү үүрэг, оролцоонд нь өнөөдөр ямар асуудал тулгамдаж байна, түүнийг шийдвэрлэх алхам дах мухардалын талаар авч үзье.

Английн яруу найрагч, улс төрийн зүтгэлтэн Жон Мильтон парламентад хэлсэн үгэндээ: “Боломж бүхий бүх төрлийн үзэл бодлын салхи чөлөөтэй салхилж байг. Үзэл бодлын чөлөөт зах зээл бий болсон үед л үнэн худлыг ялж чадна. Үнэн гэдэг бол хамгаас хүчтэй. Тиймээс хүнд худал хуурмагийн эсрэг чөлөөтэй, ил тод тэмцэх боломж олгох хэрэгтэй. Энэ бол шударга бус явдлын эсрэг тэмцэх хамгийн найдвартай, цорын ганц зөв зам мөн”²⁷ хэлсэн баримт буй. Өнөөгийн авлига гэх худал хуурмагын эсрэг тэмцэж буй хэвлэл мэдээллийн байдал, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг ямар түвшинд байгаа вэ? Өөрийн зүгээс маш муу гэсэн дүн тавьхад буруутахгүй нөхцөл байдал үүссэн гэж дүгнэж болно. Уг дүгнэлтийг дэмжиж, “мэдээллийн ажилтнууд аль нэг намын бодлогыг илэрхийлэгч болж туйлширснаас гаргаж буй бүтээгдэхүүн нь нийтэд өгөөж муутай, нэгийг магтаж, нөгөөг муулсан, хов жив, худал зүйлээр дүүрч байгаагаас хэвлэлийн үнэ цэнэ алдагдаж, иргэд итгэхээ байсан”²⁸ гэсэн судлаачын үзэл бодол гарч ирсэн байна. Эдгээрийг батлаж, АНУ-н Олон Улсын Хөгжлийн Агентлаг болон Азийн сантай хамтран явуулсан Монгол дах авлигын байдалд хийсэн үнэлгээний үр дүнгээс үзвэл, “нууцын тухай хууль одоо ч гэсэн үг хэлэх, хэвлэн нийтлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтэд саад учруулж, хязгаарлаж байна. Эрх баригчид мэдээллээс айж, иргэд, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудын мэдээлэл хүссэн хүсэлтийг биелүүлэх хүсэлгүй хэвээр байна”²⁹ гэсэн дүгнэлт хийсэн байна.

Дээрхээс дүгнэвэл, авлигатай тэмцэх олон арга зам байгаа бөгөөд тэдгээрийн зарим нь хэрэгжсэн ч бодитой үр дүн харагдахгүй байна гэдэг нь тогтоогдсон. Тэдгээр дундаас анхаарал татсан нэг арга зам бол чөлөөт хэвлэл мэдээллийн оролцооны талаар юм. Авлигын эсрэг сөрж чадах хамгийг хүчтэй хийгээд үр дүнтэй арга гэж болох хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хяналт нь өнөөгийн нийгэмд үгүйлэгдэж байна. Одоо оршин буй хэвлэл, мэдээллийн систем нь ямар мухардалд орсоныг дээр дурдсан болно. Тэгвэл, дээрх мухардалаас хэрхэн гарч болох, хараат бус, чөлөөт хэвлэл мэдээллийн оролцоогоор авлигатай хэрхэн тэмцэх талаар дараагийн хэсэгт авч үзье.

2.2. Үндэслэх хэсэг буюу асуудлыг дэвшүүлэх нь

2.2.1. Хараат бус, чөлөөт хэвлэл мэдээлэл гэж юу вэ?

Хараат бус, чөлөөт хэвлэл мэдээлэл гэж юу вэ? Энэ талаар олог байр сууринаас хандсан, олон тодорхойлолт бий. Тухайлбал, “Хэвлэлийн эрх чөлөө

²⁷ http://mn.wikipedia.org/wiki/либертари_буюу_хэвлэлийн_бүрэн_эрх_чөлөөний_онол

²⁸ Н.Отгон-Од, “Авилгал Монголд” өгүүлэл, МННХ Соросын сан, Зориг сан, “Авилгал: Мөнхийн үзэгдэл биш”, УБ, 2002, 6-р тал

²⁹ АНУ-н ОУХА, Азийн сан, “Монгол улс дах авлигын байдалд хийсэн үнэлгээ” эцсийн тайлан, УБ, 2005, 54-20-р тал

гэж хөндлөнгийн оролцоогүй, аливаа дарамт шахалтгүй байхыг хэлнэ. Хараат бус хэвлэл гэж засгийн газар, улс төр, эдийн засгийн хяналт, мөн материал, үйлдвэрлэл, түгээлтийн дэд бүтцээс хараат бус байхыг хэлнэ”³⁰ гэсэн бол “Ардчилсан нийгэмд ард түмэн мэдэх эрхтэй. Үүнийг бид мэдээллийн эрх чөлөө гэж нэрлэдэг. Мэдээллийн эрх чөлөө нь мэдээлэл хайх, олж авах, хүлээн авах, түгээх бүлэг эрхээр дамжин хэрэгждэг”³¹ гэжээ. Угтаа мэдээлэл гэдэг бол “Эрх мэдэл. Мэдээллийг олон хүн эзэмших тусам эрх мэдэл тэр хэмжээгээр тархдаг. Ард түмэн мэдээлэл олж авах бололцоотой байна гэдэг бол хүмүүс улс үндэстэндээ итгэлтэй байх нэг тулгуур зарчим... Олон нийтэд мэдээлэл хүргэх гол хэрэгсэл нь хараат бус, чөлөөт хэвлэл мэдээлэл юм”³² гэж тун хүчтэйгээр чөлөөт хэвлэл мэдээллийн мөн чанарыг тайлбарласан байна.

2.2.2. Авлигатай тэмцэхэд хараат бус, чөлөөт хэвлэл мэдээллийн оролцоо, түүний баталгаа

Францын их хувьсгалын нэрт зүтгэлтэн, улс төрийн удирдагч М.Робеспьер “хэвлэлийн эрх чөлөө гэдэг бол бүх төрлийн үзэл бодлыг чөлөөтэй нийтлэх явдал”³³ гэдгийг цохон тэмдэглэжээ. Тэгвэл энд яригдаж буй хэвлэл мэдээллийн оролцоо авлигын эсрэг асуудалд яаж холбогдож байгаа вэ? Юун түрүүнд, хэвлэл мэдээллийн бүрэн эрхийн талаар “Мэдээллийн эрх чөлөө нь хvний язгуур эрх бөгөөд... НВБ-аас тунхагласан бусад бvх төрлийн эрх, эрх чөлөөг хэмжих vндсэн хэмжvвр мөн”³⁴ гэж тунхаглажээ. Түүнчлэн энэ талаар, “Хvн бvр өөрийн vзэл бодолтой байж, тvвнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, vвнд vзэл бодлоо ямар ч хориг цээргvй баримтлах, аливаа vзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар vл хязгаарлан боломжтой арга замаар эрж сурвалжлах, олж ашиглах, тvгээн дэлгэрvвлэх эрх багтана”³⁵ гэсэн бол “Хvн бvр vзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энэ эрх нь төрөл бvрийн мэдээлэл болон vзэл санааг улсын хил хязгаар vл харгалзан амаар, бичгээр буюу хэвлэлээр, эсхvл уран сайхны, мөн өөрийн сонгосон бусад аргаар чөлөөтэй эрж хайх, хvлээн авах, тvгээх эрх чөлөө багтана”³⁶, мөн “Хvн бvр өөрийн vзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энэхvв эрх нь өөрийн vзэл бодолтой байж, мэдээлэл чөлөөтэй хайх, тvгээх эрхийг агуулна”³⁷ гэж үзсэн байна. Үндэсний хэмжээнд, “Төр, тvвний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгvй асуудлаар мэдээлэл хайх, хvлээн авах эрхтэй”³⁸ гэж тодорхойлжээ. Дээр дурдсан бүх үзэл баримтлалууд нь хэвлэл мэдээллийн

³⁰ Х.Наранжаргал, “Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний өнөөгийн байдал” нийтлэл, УБ, 2009, 1-р талд ЮНЕСКО, Олон улсын сэтгүүлчдийн холбооноос хамтран баталсан Уэндхүекийн зарчимд тунхагласан байдаг хэмээн бичжээ.

³¹ Х.Наранжаргал, “Хэвлэл мэдээллийн шударга ёс” өгүүлэл, АТГ, “Шударга ёс” сэтгүүл, 02-р дугаар, УБ, 2010, 31-р тал

³² Жереми Поуп, “Авилгалын эсрэг сурвалж бичиг”, УБ, 2003, 174-р тал, /Орч.Т.Эрдэнэбилэг, Б.Баяр нар/

³³ http://mn.wikipedia.org/wiki/либертари_буюу_хэвлэлийн_бүрэн_эрх_чөлөөний_онол

³⁴ НВБ-ын Ерөнхий Ассемблейн анхдугаар чуулга уулзалтын 59-р тогтоол, 1946

³⁵ Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, 19-р зүйл

³⁶ Иргэний болон Улс Төрийн Эрхийн тухай олон улсын Пакт, 19-р зүйл

³⁷ Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах Европын конвенц, 10-р зүйл

³⁸ Монгол улсын Үндсэн хууль, 16.17 дах хэсэг

нийгмийн харилцаа руу чиглэсэн үндсэн механизм бөгөөд авлигын асуудалд ч мөн ялгаагүй болно. Өөрөөр хэлбэл, авлигын талаар, авлига явагддаг нийгмийн харилцааны талаар мэдээлэл, баримт, бодит үнэнийг олж тогтоон, тэдгээрийг олон нийтэд мэдээлэх, тайлагнах, улмаар олон нийт, нийгэмээр тэдгээрийг хянуулах гэсэн тэрхүү механизмын оролцоо юм.

2.2.3. Авлигатай тэмцэхэд хараат бус, чөлөөт хэвлэл мэдээллийн үүрэг

“Хэвлэл мэдээллийн сургалт, судалгаагаар дагнасан мэргэжлийн байгууллагуудын зохион байгуулж буй авлигатай тэмцэх үйл ажиллагаа харьцангуй цөөн боловч нэлээд бодитой, үр нөлөөтэй байна. Харин сонин, телевиз зэрэг ХМХ-үүдийн хувьд олон нийтэд тогтмол давтамжтайгаар авлигын тухай мэдээллийг тасалдалгүй хүргэж буй боловч асуудлыг улс төржүүлэх, захиалгаар баримт, эх сурвалжгүй мэдээлэл уншигчдад өгч тэднийг төөрөгдүүлэх, үзэл бодлоо тулгах зэрэг алдаа гаргаж байна”³⁹ гэсэн судлаачийн дүгнэлт нь авлигатай тэмцэхэд хэвлэл мэдээллийн гүйцэтгэж буй ажлын үр дүнг илэрхийлжээ. Энд яригдаж буй хараат бус, чөлөөт хэвлэл мэдээллийн үүрэг авлигатай тэмцэх асуудалд яаж илэрдэг вэ? Энэ талаар, Авлигын эсрэг НҮБ-н конвенцид “олон нийт мэдээлэл авах боломжтой байх явдлыг хангах; авилгалыг үл тэвчих уур амьсгал бий болгоход хувь нэмэр оруулахад чиглэсэн олон нийтэд мэдээлэл хүргэх үйл ажиллагаа хэрэгжүүлэх; авилгалтай холбоотой мэдээлэл эрэх, авах, хэвлэн нийтлэх, тараах эрх чөлөөг хүндэтгэх, хөхиүлэн дэмжих, хамгаалах”⁴⁰ хэмээн хэвлэл мэдээллийн үүрэг, байр суурийг тодруулж өгчээ. Үндэсний хэмжээнд авлигын эсрэг тэмцэлд хэвлэл мэдээллийн үүрэг, байр суурь ямар байна вэ? Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт “авилгалын аливаа хэлбэрийг үл тэвчих сэтгэл зүйн орчин төлөвшүүлэхэд нийтлэл, нэвтрүүлгийн бодлогыг чиглүүлэн, эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хөгжүүлэх; авилгалтай холбоотой хэргийн шалтгаан, нөхцөл, тэдгээрийг арилгах арга замын тухай цуврал нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэж олон нийтэд хүргэж байх; хэвлэл, мэдээллийн байгууллага төрийн байгууллагаас мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлж, хэвлэл, мэдээлэлд үнэн зөв мэдээлэл өгдөг тогтолцоо бий болгох”⁴¹ гэж тодорхойлсон нь авлигатай тэмцэх явдалд хэвлэл мэдээллийн орших байр суурь, гүйцэтгэх үүргийг давхар тодорхойлсон хэрэг болно.

2.2.4. Авлигын эсрэг тэмцэхэд хэвлэл мэдээллийн оролцоонд тулгарч буй асуудал

Нэгдүгээрт, “Мэдээлэл олж авах боломжгүй байдал, нууцын тухай хууль зэрэг нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүргийг хязгаарлаж байна. Гүтгэхийг эрүүгийн хэрэг болгож хуульчилсан хуулиуд сэтгүүлчдийг айлгах

³⁹ Г.Цогтбаатар, “Авлигатай тэмцэхэд чөлөөт хэвлэлийн үүрэг” нийтлэл, судалгаа, УБ, 2008, 6-р тал

⁴⁰ Авлигын эсрэг НҮБ-н конвенц, 2003, 13-р зүйл

⁴¹ МУИХ, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, 2002, 3 дугаар хэсэг 8-р зүйл

хэрэгсэл болж байгаа бөгөөд болсоор ч иржээ”⁴² гэсэн судалгааны үр дүн нь авлигын эсрэг тэмцэх хэвлэл мэдээллийн оролцоонд саад болж буй мэт харагдаж байна. Гэхдээ, сүүлийн үед, олон нийтийн телевиз, сонин хэвлэл/бидний хэлж заншсанаар шар сонингууд/, мэдээллийн цахим хуудас зэргээр дамжуулан авлига гэхчлэн нийгэм, улс төр, эдийн засгийн олон асуудлыг зоригтойгоор хэлдэг болсон гэсэн дүгнэлтийг судлаачын зүгээс үзсэн болно. Учир нь профессор Л.Фоиер “Аливаа нийгэм, тэр дундаа чөлөөт/ардчилсан/ нийгэм ч гэсэн ерөөс цуу, дам үгийн системгүйгээр оршиж чадахгүй” гэсэн үгэн дээр үндэслэж “ардчилсан нийгмийн энэ үед олон ургальч үзэл, үг хэлэх эрхийг задгай тавьж, хардалтын системийг баталгаажуулж өгснөөр хариуцлага, үүрэг алдагдаж түүнийг хэтрүүлэн хортойгоор ашиглаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хөл толгойгүй олон мэдээлэл, хуурмаг, нэн бүдүүлэг зүйлс тарж байна гэж олонхи үзвэл, засаг төр яах ёстой вэ? Энэ асуултад иргэд үзэл бодлоо нээлттэй солилцсоны үр дүнд үнэн худлыг ялгаж, бусдын үнэт зүйл, хууль ёсны ашиг сонирхлыг илүү ойлгож, асуудлынхаа утга учрыг мэдэх, харилцан буулт хийх чадвар буй болсон цагт амжилтад хүрнэ хэмээн итгэх хэн ч бай хариулахдаа: «Өнөөгийн эрх зүйт төрд энэ асуудлаар засаг төр юу ч хийх аргагүй. Энэ бол ердөө тэдний хэлэлцэн шийдвэрлэх асуудал биш. Харин ерөнхийдөө чөлөөтэй үгийг илүү чөлөөтэй үгээр л эмчилж болно»⁴³ гэж хуульч Тэмүүжиний өгүүлсэн үзэл санааны дор өнөөгийн олон нийтийн сүлжээнд/social network/ өөрийн өнгө аясыг илэрхийлсэн мэдээ, мэдээлэл, шүүмж гарч ирж байгаа гэж ойлгогдоно. Тэгвэл асуудал хаана, юунд байна вэ? Уг нь бол “олон нийтийн хэлэлцүүлэг буюу хүн бүр өөр өөрийн үзэл бодлоороо нийгэмтэйгээ чөлөөтэй харилцах энэ харилцаа ардчилал, нээлттэй нийгмийн үзэл санаа иргэний нийгмийн хөгжилд дулдуйдан орших тэр цагт илүү утга агуулгатай болж, тэр хэрээрээ илүү ухаалаг мэдээллийн орон зайг нийгмийн оюун санаанд бий болгодог”⁴⁴ гэдэг боловч, “Хэвлэлийнхэн есөн шидийн хэрүүл шуугианд байнга анхаарлаа төвлөрүүлээд авлигатай холбогдсон их дуулиант хэргийн тоог бууруулдаг шинэтгэлийг нэг их сонирхохгүй байдаг. Үндсэндээ шинэтгэлийг идэвхтэй дэмжигчид нь цөөн хэдэн иргэд, олон нийтийн байгууллагууд болдог. Харин хувь хүмүүсийн тухайд гэвэл тэд илэрхий үлбэгэр зогсонги байдлаасаа хохирдог. Зарчмын хувьд, тэд ямар ч мэдээлэл авах боломжтой байдаг ч уг мэдээлэлтэй танилцах ямар нэгэн сонирхол тэдний дийлэнхэд бий болдоггүй байж мэдэх юм. Хэвлэлд сүр бадруулан илчлэхэд уншигчдын зэвүүцэл төрж мэдэх ч, тэднийг идэвхтэй үйлдэлд хүргэж чаддаггүй”.⁴⁵ Энд яригдаж буй идэвхгүй, үлбэгэр хувь хүмүүс гэдэг нь “Улс үндэстний шударга ёсны тогтолцооны амин чухал дэмжлэг бол

⁴² АНУ-н ОУХА, Азийн сан, “Монгол улс дах авлигын байдалд хийсэн үнэлгээ” эцсийн тайлан, УБ, 2005, 20-р тал

⁴³ Х.Тэмүүжин, “Ардчилал дах олон нийтийн хэлэлцүүлэг ба хэвлэл, мэдээллийн эрх чөлөө” нийтлэл, “Jus frast буюу Ёст үг”, УБ, 2003, 86-87-р тал

⁴⁴ Х.Тэмүүжин, “Ардчилал дах олон нийтийн хэлэлцүүлэг ба хэвлэл, мэдээллийн эрх чөлөө” нийтлэл, “Jus frast буюу Ёст үг”, УБ, 2003, 85-р тал

⁴⁵ С.Р.Аккерман, “Авлига, төр хоёр: Шалтгаан, үр, шинэтгэл”, УБ, 2007, 234-р тал /Орч. Ц.Цэрэн, Ж.Төртогтох/

өөрийн эрхийг мэдэж ухамсарласан, мэдээлэлтэй иргэд. Харин идэвхгүй, эрхээ үл тоомсорлосон, албан тушаалыг урвуулан ашиглах явдалтай эвлэрдэг олон нийттэй бол намайг хэн хэлэх вэ, нохойг хэн саах вэ гэсэн уур амьсгал бий болж авлига цэцэглэх үржил шимтэй хөрсийг бэлдэж өгөх”⁴⁶ аюултай байдаг байна.

Тэгвэл энэхүү олон нийтийн эд эс болдог хувь хүний идэвхгүй, сул байдлаас үүсэх, авлигалд холбогдох асуудлыг хэрхэн шийдвэрлэх өнцгөөс нь авч үзэх вэ? Энэ талаар дараах хэсэгт хэвлэл мэдээлэл, олон нийтийн эвлэл, холбоо, иргэний нийгэм гэсэн ухагдахуунуудаар дамжуулан авч үзье.

2.3. Тогтоох хэсэг буюу асуудалд гарц хайх нь

2.3.1. Иргэний нийгэм дэх олон нийтийн эвлэл холбоо

Иргэний нийгэм нь “үндсэндээ хууль ёсны эрх мэдлээ хүний эрх, байгаль орчин, эрүүл мэнд, боловсрол, авлига зэрэг олон нийтийн ашиг сонирхлыг илэрхийлсэнээр олж авдаг”⁴⁷ ба “хүмүүс хамтран нэгдэж, үзэл бодлын хүрээгээрээ өөрсдөө зохион байгуулагдах”⁴⁸ тэр тогтолцоог хэлдэг. Мөн нөгөө талаас, иргэний нийгэм гэдэг нь “өөр өөрсдийн онцлогийг хадгалсан бүлэг хэсгүүд, ашиг сонирхлын ялгаварлалд хуваагдах нь олон ургальч үзэл, нийгмийн уг чанарт салшгүй оршихын баталгаа болдог бөгөөд иргэний нийгэм хөгжингүй эсэх асуудлын хамгийн чухал үзүүлэлт энэ байдаг”⁴⁹ гэжээ. Энд яригдаж буй үзэл бодол, ашиг сонирхлоороо нэгдэн, зохион байгуулагдсан бүлэг, хэсэг гэдэг нь угтаа олон нийтийн байгууллага, эвлэл, холбоод юм. Энэ талаар олон тодорхойлолт, тайлбар байх боловч, академич С.Нарангэрэлийн үзсэнээр, “Олон нийтийн байгууллага гэх нэр томъёо нь Үндсэн хуульд тусгалаа олсон боловч олон нийтийн байгууллага, төрийн бус байгууллага, засгийн газрын бус байгууллага гэсэн ойлголтуудын харилцан хамаарал, зааг ялгааны талаар нэг мөр ойлголт тогтоогүй”⁵⁰ гэж тайлбарлажээ. Эндээс, олон нийтийн эвлэл холбоо, байгууллага гэдэг нь нэг зорилго, ашиг сонирхол бүхий нийгмийн гишүүд тухайн зорилгодоо хүрэх, ашиг сонирхолоо хэрэгжүүлэхийн тулд нэгдэж, нийгэмд чиглэсэн тодорхой үйл ажиллагаа явуулж буй, зохион байгуулалт бүхий иргэдийн бүлэг, эвсэл гэсэн тодорхойлолт өгч болохоор байна.

2.3.2. Авлигатай тэмцэхэд олон нийтийн эвлэл холбооны гүйцэтгэх үүрэг

Нэг л том үүрэг бий. Аливаа зүйл ганцхан байх тусмаа хүчтэй бас тэгээд хэврэг байдаг. “Том, жижиг авлига. Энэ бол авлигын хамгийн түгээмэл ангилал. Ерөнхийдөө жижиг авлигад өдөр тутмын буюу эмнэлэг, сургууль, цагдаагийн хэлтэс болон хүнл суртлын бусад байгууллага орно... Жижиг авлигын үйлдэлд

⁴⁶ Жереми Поуп, “Авилгалын эсрэг сурвалж бичиг”, УБ, 2003, 334-р тал, /Орч.Т.Эрдэнэбилэг, Б.Баяр нар/

⁴⁷ Жереми Поуп, “Авилгалын эсрэг сурвалж бичиг”, УБ, 2003, 191-р тал, /Орч.Т.Эрдэнэбилэг, Б.Баяр нар/

⁴⁸ <http://www.medeel.mn/medleg/> /”Мэдлэг” мэдээллийн вебсайт/

⁴⁹ Х.Тэмүүжин, “Jus frast буюу Ёст үг”, УБ, 2003, 85-р тал

⁵⁰ С.Нарангэрэл, “Хууль зүйн тайлбар толь”, УБ, 2003 он,

үнэлгээ, тэр чинээгээр хяналт тогтооход өрхийн түүвэр судалгаа чухал ач холбогдолтой”⁵¹ гэсэн бол том авлигыг үнэлэх, хяналт тогтоох арга зам бол олон нийтийн, төрийн бус байгууллага юм. Хамгийн том жишээ дурдахад, дэлхийн тавин оронд салбартай, авлигтай тэмцэхэд ажлаа зориулдаг олон улсын олон нийтийн “Трэнспэрэнси интернэшнл”⁵² гэх зэргийн байгууллага юм. Энэ байгууллага нь олон улсын түвшинд, авлигын эсрэг дуу хоолойгоо нэгтгэж, тандалт судалгаа явуулж, сургалт семинар зохион байгуулж, шийдвэрлэх арга зам, алхам, зөвлөмж, мэдээллийг боловсруулан нийгэмд хүргэж байдаг. Энэ ч чинээгээрээ аливаа улсын нийгэмд бугшаад буй авлигын эсрэг тодорхой үр дүн бүхий арга хэмжээ авч чаддаг нь практик, судалгаа шинжилгээнээс харагддаг. Ерөөс, авлигатай тэмцэхэд олон нийтийн эвлэл холбоо, байгууллагын гүйцэтгэвэл зохих үүрэг бол дээрхийн жишээ юм.

2.3.3. Хараат бус, чөлөөт хэвлэл мэдээллээс олон нийтийн эвлэл, холбоо руу

Дээр дурдсанчлан, хэдий хэвлэл мэдээллийн зүгээс нийгэмд чиглэсэн авлигын мэдээллийг хүргэж байгаа боловч, хувь хүмүүс, нийгмийн нэг бие даасан иргэд нь тун их идэвхгүй, үлбэгэр байдалтай байдаг учраас тухайн авлигын талаарх мэдээг сонсоод зэвүүцэл төрж мэдэх ч, идэвхтэй үйлдэл хийх сонирхол, сэдэл байдаггүй байна. Иймэрхүү байдлаар, идэвхгүй, эрхээ үл тоомсорлосон, албан тушаалыг урвуулан ашиглах явдалтай эвлэрдэг олон нийттэй бол намайг хэн хэлэх вэ, нохойг хэн саах вэ гэсэн уур амьсгал бий болж авлига цэцэглэх үржил шимтэй хөрс бий болдог. Улмаар авлига гэгч нь “ардчилсан хөгжлийг сааруулж, төрийн байгууллагын үйл ажиллагаа болон нөөц бололцоог хамгийн үр ашигтай ашиглах явдалыг хязгаарладаг”⁵³ ба энэ байдал даамжирвал, нөгөө талаар “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөгүйгээр олон нийтийн хэлэлцүүлэг гэж байхгүй. Мэдэх эрхээр хангагдахгүйгээр иргэд хэзээ ч энэхүү хэлэлцүүлэгт өөрийн гэсэн санаа бодолтой оролцож чадахгүй. Өөрийн гэсэн санаа бодолгүй газар иргэний нийгэм төлөвших үндэсгүй бөгөөд энэ үндэсгүй нь хувь хүний эрх чөлөөг үгүйсгэж, ардчиллыг замхруулах аюул ямагт болж байдаг”⁵⁴ гэсэн нь улс үндэстний оршин тогтнох тогтолцоо, бүрдүүлэгч ард түмний эрх ашигт сөрөг нөлөөлөл учруулсан нөхцөл байдалд хүрнэ гэдгийг илтгэжээ. Тэгвэл энд, энэ бүхний өөдөөс сөрж зогсох боломжтой, өөрөөр хэлбэл авлигатай эвлэрсэн, үлбэгэр иргэдийг хөдөлгөөнд оруулж, идэвхжүүлэн, авлигын эсрэг тэмцэлд иргэдийг зохион байгуулалтанд оруулж, нэгдүүлэн, авлигын асуудалд хяналт тавиулдаг, дарамт шахалт болгон айлгадаг тогтолцоо, арга механизм бол олон нийтийн байгууллага, эвлэл, холбоо гэж ойлгоно. Энэ талаар, “Засгийн газар нийгмийн эрх ашгийн төлөө ажилладаг байхын тулд

⁵¹ НҮБХХ, “Авлигыг хэмжихүй” хэрэглэгчийн гарын авлага, УБ, 2008, 17-р тал

⁵² Жереми Поуп, “Авилгалын эсрэг сурвалж бичиг”, УБ, 2003, 235-р тал, /Орч.Т.Эрдэнэбилэг, Б.Баяр нар/

⁵³ Жереми Поуп, “Авилгалын эсрэг сурвалж бичиг”, УБ, 2003, 68-р тал, /Орч.Т.Эрдэнэбилэг, Б.Баяр нар/

⁵⁴ Х.Тэмүүжин, “Jus frast буюу Ёст үг”, УБ, 2003, 85-р тал

түүнд нөлөөлөх нь иргэний хяналтын зорилго байдаг бол, дарамт шахалт үзүүлэх зохион байгуулалт бүлгүүд, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд хамгийн чухал”⁵⁵ байдаг гэж дэвшүүлсэнд үндэслэж, сая дурдсан иргэний хяналт, дарамт шахалт үзүүлэх зохион байгуулалт бүлгүүд, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд “Ашгийн бус байгууллага, олон нийтийн эвлэл холбоод байгуулахыг зөвшөөрсөн хуулиуд нэн ашигтай”⁵⁶ гэсэн чиг баримжаа байгаа юм.

III. Дүгнэлт хэсэг

3.1. Дүгнэлт

Америкийн нийтлэлч Уайт “Эрх чөлөөт орны сонин хэвлэл их сайндаа бус харин туйлын олон үзэл бодлыг илэрхийлдэгээрээ нэн найдвартай, ашигтай байдаг юм. Ер нь өөрсдийнхөө үнэнийг эрсэн олон эзэд байх тутам ард олон тэдний тухай шүүн ярилцаж, бодит үнэнийг ойлгох боломжтой болдог... чухамдаа энд тооны олонд л баталгаа нь байгаа юм” гэж хэлсэнчлэн, ерөөс чөлөөт хэвлэл мэдээлэл гэдэг нь нийгмийн бүхий л асуудалд хамгийн том цензур байдаг. Тэр дундаа авлигын хэргийг олон нийтэд илчлэх, тэдгээрийг хуулийн байгууллагад хүргүүлж хариуцлага хүлээлгэх, үнэн бодит байдлыг иргэдэд түгээн улмаар зүй бус, шударга бус үйлдэл хийж, авлига авсан этгээдийг нийтээр жигшүүлэх, бусад этгээдүүдэд айдас бий болгох зэрэг олон давуу талыг бий болгож байдаг. Гэвч энд яригдаж буй иргэд, хувь хүмүүс гэдэг нь хэтэрхий сул, идэвхгүй, үлбэгэр байдаг талаар судлаач нар үздэг. Ийм иргэд нь ч олонхи байдаг. Нийгэм дэх мэдээллийг үзээд идэвхтэй үйлдэл хийдэггүй, нэг ёсондоо авлигатай эвлэрч суудаг иргэд байгаа орчин нөхцөл нь нөгөө талаар авлига цэцэглэх илүү таатай боломж бүрддэг талаар дээр өгүүлсэн. Иймд, дээрх хэвлэл мэдээллийн олон нийт, иргэдийг тулгуур болгож авлигын эсрэг хийж буй тэмцэл нь мухардалд орж, хүчгүйдэж эхэлдэг. Тэгвэл, хэвлэл мэдээллийн үүрэгт ажлыг биелүүлж, илчилсэн авлигын хэргийг хуулийн байгууллагаар хэлэлцүүлэх, хэрэгт холбогдогч этгээдүүдийг жигшиж, үл зөвшөөрөх, улмаар нийгэмд авлигын эсрэг уур амьсгалыг бий болгоход, энэ явдалын гол цөм болох ёстой иргэд, хувь хүмүүсийг идэвхтэй оролцуулж, хүчтэй байлгахын тулд олон нийтийн эвлэл холбоо, байгууллага чухал үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, иргэд тодорхой төлөвлөгөө, зорилгын дор нэгдэн, зохион байгуулалтад орж хэвлэл мэдээлэлтэй хамтран авлигын хэргийг илчилдэг, хянадаг, хуулийн хариуцлага хүлээлгэхийг шаарддаг, авлига авдаг, авах сонирхолтой этгээдүүдийг нийтээр жигшдэг, дарамт шахалт учруулдаг, айх сэтгэл зүйг бий болгон авлига авъя гэсэн хүслийг нь хаяуулж чаддаг тогтолцоо чухал гэсэн дүгнэлтэд хүрсэн болно. Угтаа, ардчилсан тогтолцоо бүхий, иргэний нийгэмт улсын иргэдийн эдлэх ёстой эрх, биелүүлэх ёстой үүрэг нь өөрөө энэ.

⁵⁵ С.Р.Аккерман, “Авлига, төр хоёр: Шалтгаан, үр, шинэтгэл”, УБ, 2007, 231-232-р тал /Орч. Ц.Цэрэн, Ж.Төртогтох/

⁵⁶ С.Р.Аккерман, “Авлига, төр хоёр: Шалтгаан, үр, шинэтгэл”, УБ, 2007, 235-р тал /Орч. Ц.Цэрэн, Ж.Төртогтох/

3.2. Санал, зөвлөмж

Дээрх бүгдээс үндэслээд, судлаачын зүгээс дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна.

- Авлигын эсрэг тэмцэлд иргэд хувь хүмүүсийг идэвхтэй оролцуулах үүднээс, авлигын эсрэг олон нийтийн байгууллага, эвлэл холбоод/Иргэний нийгмийн байгууллагууд/-ыг байгуулах, тэдгээрт иргэд, хувь хүмүүс нэгдэх боломжийг бүрдүүлэх.
- Хэвлэл, мэдээллийн байгууллага болон дээрх олон нийтийн эвлэл холбоо хоёрын хоорондох харилцааг өргөжүүлэн, авлигын эсрэг тэмцэлд харилцан уялдаа холбоотойгоор оролцдог болох.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.

IV. Ашигласан материал

А. Ном, сурах бичиг

1. Жереми Поуп, “Авлигын эсрэг сурвалж бичиг”, УБ, 2003, /Орч.Т.Эрдэнэбилэг, Б.Баяр нар/
2. Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн Соросын сан, Зориг сан, “Авилгал: Мөнхийн үзэгдэл биш”, УБ, 2002,
3. Ж.Бумнанжид, Ш.Мягмарцэрэн, “Авлига, албан тушаалын гэмт хэрэг мөрдөх аргачлал”, УБ, 2011
4. Д.Зүмбэрэлхам, “Авлигын гэмт явдал” гарын авлага, УБ, 2007
5. О.Мөнхбат, “Төрийн худалдан авах ажиллагаа болон Авлига”, УБ, 2009
6. МҮХАҮТ, “Монголын эдийн засаг, гадаад худалдааны “Цагаан ном”, УБ, 2009
7. Зориг сан, “Авлига: Түүний тухай ойлголт, тэмцэх арга зам”, УБ, 2008
8. О.Баттулга, “Коррупцийн ойлголт, мөн чанар”, УБ, 1995
9. С.Р.Аккерман, “Авлига, төр хоёр: Шалтгаан, үр, шинэтгэл”, УБ, 2007, /Орч. Ц.Цэрэн, Ж.Төртогтох/
10. Л.Батжав, Б.Цэвээн, “Ашиг сонирхлын зөрчлөөс авлига руу”, УБ, 2009
11. Х.Тэмүүжин, “Jus frast буюу Ёст үг”, УБ, 2003
12. Бемби сан, “Авлигатай тэмцэх үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт”, УБ, 2005
13. Томас Маейр, “Нийгмийн ардчиллын ирээдүй”, УБ, 2009, /Орч. Ч.Оюунгэрэл/
14. НҮБ-н Хөгжлийн хөтөлбөр, “Авлигыг хэмжихүй” хэрэглэгчийн гарын авлага, УБ, 2008
15. Л.Батжав, “Гэмт явдал: Түүний шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх асуудал”, УБ, 2002
16. Л.Батжав, Б.Цэвээн, “Ашиг сонирхолын зөрчил”, УБ, 2009
17. МҮХАҮТ, “Авилгалын эсрэг тэмцэлд хэвлэл мэдээллийн байгууллагуудын оролцоог эрчимжүүлэх нь” эмхтгэл, УБ, 2002
18. Зориг сан, “Ерөнхийлөгчийг огцруулсан сэтгүүлчийн нөр их хөдөлмөр” гарын авлага, УБ, 2004
19. Авлигатай тэмцэх газар, “Авлигын эсрэг цагаан толгой”, УБ, 2010
20. Нээлттэй нийгэм хүрээлэн, “Европын холбоонд элсэх үйл явцыг хянах нь: Авилгал ба авилгалтай тэмцэх бодлого”, УБ, 2002
21. Австралийн Олон улсын Тусламжийн байгууллага(AusAID), **“Олон нийтийн мэдэх эрх, мэдээллийн эрх чөлөө” гарын авлага, УБ, 2002**

В. Өгүүлэл, нийтлэл

1. Г.Цогтбаатар, “Авлигатай тэмцэхэд чөлөөт хэвлэлийн үүрэг” нийтлэл, судалгаа, УБ, 2008
2. **Ц.Энхбат, “Авилга ба Иргэний нийгэм” өгүүлэл**
3. **Д.Гантуяа, “Ертөнцөд авлига байдгын учир” өгүүлэл, УБ, 2007**
4. **Х.Наранжаргал, “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний өнөөгийн байдал” нийтлэл, УБ, 2009**

5. Фридрик Эрикссон, “Мэдээллийн эрх чөлөө, авилга” илтгэл
 6. **Д.Солонго, “Мэдээллийн эрх чөлөө, Үндсэн хуулийн үзэл баримтлал”, илтгэл**
- C. Хууль тогтоомж, эрх зүйн акт
1. Монгол улсын Үндсэн хууль, 1992
 2. Авлигын эсрэг хууль, 2006
 3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, 2002
 4. Авлигын эсрэг НҮБ-н конвенц, 2003
 5. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, 2011
 6. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай, 1998
- D. Судалгаа, шинжилгээний тайлан
1. Зориг сан, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт” мониторингийн судалгаа, УБ, 2004
 2. МУИС, “Авлигыг дэмжигч болон хориглогч хүчин зүйлс” судалгааны тайлан, УБ, 2007
 3. Тодд Лэндмэн, Марко Ларицца, Клэр Макэвой, “Монгол дахь ардчиллын төлөв байдал”, урьдчилсан судалгаа, УБ, 2005
 4. АНУ-н ОУХА, Азийн сан, “Монгол улс дахь авлигын байдалд хийсэн үнэлгээ” эцсийн тайлан, УБ, 2005
- E. Мэдээллийн цахим хуудас
1. www.wikipedia.org
 2. www.legalinfo.mn
 3. www.ardchilal.com
 4. www.iaac.mn
 5. www.globeinter.org.mn
 6. www.forum.mn
- F. Гадаад хэл дээрх эх сурвалж
1. Representative on freedom of the media organization on security and co-operation in Europe, “Freedom of the media and corruption”, Fourth central asian media conference, Tashkent, 26-27 September 2002, Vienna 2003 /Европ дахь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний байгууллагын аюулгүй байдал, хамтын ажиллагааны төлөөлөгчийн газар, “Хэвлэлийн эрх чөлөө ба Авлига”, Төв Азийн 4 дэх удаагийн Хэвлэл мэдээллийн хэрэгслийн зөвлөлгөөн, Ташкент 2002 оны 9-р сарын 26-27-нд, Вейнн, 2003/
 2. 高信 麻、「イギリス」賄賂防止法案、2009 年 /Такашин Аса, “Англи” авлигаас хамгаалах хуулийн төсөл, 2009/
 3. OECD 政策フォーカス、「賄賂・汚職との闘い」、2001 年 /Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага-Бодлогын төв, “Авлига, албан тушаалаа урвуулан ашиглахтай тэмцэх нь”, 2001/

